

ДЭЛ УУЛЫН ДУРСГАЛТ ГАЗАР “ДЭЛ УУЛ”-ЫН ТАНИЛЦУУЛГА

Дэл уул нь Дундговь аймгийн Өлзийт, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумдын нутгийг дамнан оршдог занар чулуунаас бүрдсэн, байгалийн өвөрмөц тогтоцтой, аргал, янгир, хар сүүлт зэрэг ан амьтантай, төрөл бүрийн эмийн ургамалтай, булаг шанд, хайлаас, сухай элбэгтэй эко системийн хувьд нэлээн ховорт тооцогдох нутаг.

Дэл уул нь чулуун зэвсгийн үеэс эхлэн 19-р зуун хүртэлх хэдэн мянган жилийн түүх өгүүлэх дөрвөлжин булш, хигисүүр зэрэг археологийн төрөл бүрийн олдвор элбэгтэй нутаг. Үүнийн дотроос хамгийн элбэг нь 5000 орчим хадны зураг юм.



Дэл ууланд хадны зураг, руни бичээс, ханз үсэг, уйгуржин, түвд бичээс, шоргоолжин булш, дөрвөлжин булш, хиргисүүр, буган хөшөө, зэл чулуу, хадны оршуулга, сүм хийдийн туурь, чулуун зэвсгийн үлдэгдэл зэрэг дурсгалууд бий. Эдгээрийн дотроос хүн төрөлхтний болон нүүдэлчдийн аж ахуй оюун санааны хөгжлийг хадгалж үлдсэн гайхамшигт дурсгал болох хадны зураг нь Монгол орны говийн бүсийн томоохон дурсгалт газрын төлөөлөл юм.

Дэл уул нь түүх соёлын дурсгал элбэгтэйгээс гадна занар чулуунаас бүрдсэн, байгалийн маш өвөрмөц сонин тогтоцтой, аргал, янгир, хар сүүлт зэрэг ан амьтан элбэгтэй, эмийн олон төрлийн ургамалтай эко системийн хувьд өвөрмөц нутаг юм.

Дэл уулын Баруун Зүүн билүүний хэсэгхэн газарт байгаа 5000 орчим хадны зураг нь хуучин чулуун зэвсгийн неолит, хүрэл зэвсэг, төмрийн түрүү үе, хүннү, түрэг гэх мэт хоорондоо хэдэн мянган жилийн зайтай цаг үед таван удаа зурагдсаныг судлаачид тогтоосон байдаг. Монголын хамгийн анхны бичиг үсгийн нэг болох руни буюу Орхоны бичээс, Тан улсын үед холбогдох эртний ханз бичгийн дурсгал, хадан дээр зурагдсан үлэмж том биетэн, бүжиглэж буй 20-30 хүний дүрстэй дөрвөлжин булшнууд, цонхтой гэр, буруу харсан хас, дөрвөн дугуйтай тэмээн тэрэг, үхэр тэрэг зэрэг жуулчдын анхаарлыг татдаг дурсгалууд олон байдаг. Дэл уулын энэ орчинд хадны зургийг дахин дахин зурж байсан нь тэнд хүн оршин суух байгалийн зохицолдлогоо сайтай, ан амьтан элбэгтэй, шүтлэгийн аливаа үйл хийх нөхцөл бүрдсэн давуу талтай учраас эерэг эрч хүчний хуйлрал эргэлдсэн газар байх магадлалтай хэмээн зарим судлаачид таамаглал дэвшүүлдэг. Дэл ууланд хадны зургаас гадна өвөрмөц хийцтэй агуй, мөргөцөг, хонгио, мухар таг, хадан хясаан ам зэрэг байгалийн өвөрмөц тогтцыг урлагийн тайз, задгай театр, хурлын танхим болгож ашиглах боломж байдаг.

Энд буй хэдэн мянгаар тоологдох хадны зураг нь дүрслэл, өгүүлэмж, түүхэн ач холбогдлын хувьд бусдаас илүү өвөрмөц учраас 2007 онд ЮНЕСКО-гоос Дэл уулыг “Дэлхийн соёлын өв”-д бүртгэгдэх урьдчилсан жагсаалтад оруулсан.

ДЭЛ УУЛ ОРЧМЫН ГАЗАР ЗҮЙ, ГЕОМОРФОЛОГИ

Дэл уул нь өргөргийн дагуу 30-аад км урт, 8 км өргөнтэй сунаж тогтсон, хуудаслаг босоо занар чулуунаас бүрдсэн улаан хүрэн өнгийн өвөрмөц чулуун гадаргуу бүхий намхан уул юм. Уулын гадаргуу эгнэсэн олон дэл мэт урт урт толгодоос бүрддэг тул эртнээс “Дэл” хэмээн нэрлэгдсэн домогтой.



Дэл уул орших Дундговь аймгийн Өлзийт сумын өмнөд хэсэг нь Монгол орны физик газар зүйн мужлалтаар Говийн их муж, Дорнод говийн мужийн Умарт говийн ухаа, гүвээт талын тойрогт хамаарна. Энэхүү тойргийн гадарга нь ухаа гүвээт тал зонхилохын хамт урд захаар нь Хөнжил, Их Шанхай мэт уулс болон цав толгод голчилдог байна [Монгол орны физик газар зүй, 1969, 398].

Намхан уулс, толгод гүвээ, хөндий цайдмууд хосолсон гадаргуутай, энэхүү геоморфологийн элементүүд нь ерөнхийдөө өргөгдлийн дагуу нарийн зурвас үүсгэн сунаж байрладаг. Энэ хавийн нутаг нь хотгор гүдгэрийн үндсэн хэв шинжээрээ Ухаа гүвээт тал нутагт хамаарах юм. Дэл уул орчмын нутаг нь Алтайн ар говийн цав толгод нутагт хамаарч байна.

Газрын гадаргад уул толгод, хотос, ухаа гүвээ, уудам хөндий бүхий нутаг бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1200-1400 метр орчим байна. Хамгийн өндөр цэг нь 1421 м орших Дэл уул. Дэл уулын орчмын нутгийн ихэнх хэсгийг нам уулс, цав толгод, тэдгээрийн хооронд үргэлжлэх хөндий хоолой эзэлнэ.

Дэл ууланд хайлаас мод, заг, сухай модлог, хүнсний болон эмийн төрөлд хамрагдах гоёо, цулхир, зээрийн ундаа, чихэр өвс, хармаг, тэмээн хөх, хүмүүл, цулбуур цахилдаг, юм дүүжин зэрэг олон төрлийн ургамалтай.

Амьтны аймгийн хувьд говийн энэ шаргал хөрсөнд идээшсэн аргаль, янгир, хар сүүлт, үнэг, хярс, цагаан зээр, чоно зэрэг ан амьтад нутаглана. Мөн тас, бүргэд, харцага, ногтруу, ууль, шар шувуу зэрэг хээр талын жигүүртэн шувууд нэн олон.

ДЭЛ УУЛЫН АРХЕОЛОГИЙН ОЛДВОРУУД

Дэл ууланд рунни, хятад ханз, хуучин монгол, түвд зэрэг бичээс, хадны зураг, шоргоолжин болон дөрвөлжин булш, хиргисүүр, гэрэлт хөшөө, хүн чулуу, хот балгасны үлдэгдэл, сүм хийдийн туурь зэрэг түүх, соёлын дурсгал бий. Эдгээрээс хамгийн олон тоотой, хамгийн анхаарал татаж буй нь хадны зураг юм. Энд байгаа хадны зураг нь хуучин чулуун зэвсгийн, хүрлийн, төмрийн түрүү үе, хүннүгийн зэрэг хоорондоо мянга мянган жилийн зайтай таван удаа зурагдсан гэж судлаачид үздэг.



ДЭЛ УУЛЫН ДУРСГАЛТ ГАЗРЫН СУДЛАГДСАН БАЙДАЛ



Дэл уулын дурсгалт газрын судалгаа 1960-аад оноос Оросын эрдэмтэн А.П.Окладников, Монголын эрдэмтэн Н.Сэр-Оджав, Д.Дорж нар эхэлсэн бөгөөд 1969 онд Э.А.Новгородова, Д.Дорж нар, 1987 онд Д.Хүүхэнбаатар, Т.Санжмятав, 1988 онд В.В.Волков, Д.Хүүхэнбаатар, Т.Санжмятав нар үргэжлүүлэн судалсан байдаг. 1995 онд Түрэгийн үеийн руни үсгийн нэг, гурав дугаар бичээснүүдийг доктор Д.Хүүхэнбаатар, Ю.Болдбаатар, II, IV, V бичээс, Жирмийн худгийн бичээсийг Ц.Баттулга нар уншиж судалсан байна. Түүнчлэн гэр сууцны зургийн талаар И.Жанболот, Жигмэддорж, Баатархүү нар, цэргийн аяны тухай Б.Батсүрэн, Д.Хүүхэнбаатар гэх мэт олон эрдэмтэд эрдэм шинжилгээний олон өгүүлэл бичиж, Д.Цэвээндорж, Н.Батболд нар 2005 онд “Дундговь аймгийн Дэл уулын Билүүний хадны зураг” нэгэн сэдэвт бүтээлийг анхлан гаргаж, доктор Д.Сүхбаатар Дэл уулын хадны зургаар баримтат кино, гэрэл зургийн цомог гаргасан байна. 1990 оноос МУИС-ийн Түүхийн ангийн оюутнууд багш нар танилцах дадлагыг энд тогтмол хийж байна.

ДЭЛ УУЛЫН ХАДНЫ ЗУРГИЙН БУСДААС ЯЛГАРАХ ОНЦЛОГ

Дэл ууланд монголчуудын хэрэглэж байсан бичиг үсгийн нэг болох рунни бичиг, Тан улсын үед бичигдсэн хятад ханз үсэг, бүжиглэж буй 23-32 хүнийн дүрс бүхий дөрвөлжин булшнууд, Уйгарын үед зурагдсан олон морьтой хүмүүс, цонхтой гэр, хүрээ бүхий буруу эргэлттэй хас тэмдэг, туурайндаа дугуйтай адуу, үлэмж том биетэй хүн, дөрвөн дугуйтай тэмээн тэрэг, монголд олдсон хадны зургаас хамгийн том хэмжээтэй морин тэрэг, монгол бөхийн барилдаан, хүннү тамганы дүрс зэрэг бусад газраас тэр болгон олдоогүй өвөрмөц зургууд олон байдаг.

Монгол орны хадны зурагтай газруудад байдаг бүх төрлийн зураг Дэл ууланд байдаг, зарим хадны зураг нь урлагийн бүтээл мэт уран нарийн загвар хийсвэрлэл ихтэй, төрөл бүрийн тамга тэмдэг бусад газраас элбэг гэж судлаачид үздэг.

Дэл уулын энэ орчинд хадны зургийг хоорондоо хэдэн мянган жилийн зайтайгаар дахин дахин зурж байсан нь тэнд хүн оршин суух байгалийн өвөрмөц зохицолдлогоотой, ан амьтан элбэгтэй, шүтлэгийн аливаа үйл хийх нөхцөл бүрдсэн зэрэг байгалийн эерэг энерги хуримтлагдсан газар хэмээн зарим судлаачид үздэг юм билээ. /Н.Батболд "Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа" 56-р хууд/

ДЭЛ УУЛЫГ ХАМГААЛЖ ИРСЭН ТҮҮХ

1. Монгол Улсын УИХ-ын 1998 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Дэл уул орчмын 279021,46 га газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.
2. МУ-ын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор Дэл уулын Баруун билүүн болон Өлзийтийн хуудасны хэд хэдэн хадны зураг, бичгийн дурсгалууд улсын хамгаалалтад авах түүх соёлын дурсгалт газруудын жагсаалтад орсон.
3. МУ-ын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор шинэчлэгдэн баталсан Улсын хамгаалалтад авах түүх соёлын дурсгалт газруудын жагсаалтад Дэл уулын Баруун Билүүний хадны зураг рунни бичээс, Хамар ус, 32 хүн хөшөөт хэмээх газар орших хадны зураг, дөрвөлжин булш цогцолбор дурсгал орсон.
4. 2019 онд БОАЖЯ-наас Дэл уул орчмыг улсын тусгай хамгаалалтад оруулах шийдвэр гарсан. Энэ шийдвэрийн дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн судалгааны төвийн захирал, доктор (Sc.D) Б.Оюунгэрэл, агнуур зүйч, доктор С.Амгаланбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ажилтан, доктор С.Хүрэлсүх, Олон улсын байгаль хамгаалах "The Nature Conservancy" /TNC/ байгууллагын ажилтан Э.Анхбаяр нарын бүрэлдэхүүнтэй баг байгаль орчин, соёлын дурсгалт зүйлийн талаар дүгнэлт гаргасан. Улсын тусгай хамгаалалтад авах ажил 2022 онд эцэслэн дуусах ёстой.
5. 2020 онд МУ-ын Засгийн Газрын "Чулуун соёлын өв" хөтөлбөрийн хүрээнд Соёлын өвийг хамгаалах хуулийн 25.1 дүгээр заалтын дагуу Дэл уулыг бүхлээр нь түүх соёлын дурсгалт газрын ангиллаар кадастрын улсын бүртгэлд бүртгэх шийдвэр гарч кадастрын зураглал хийгдсэн. Энэ бүртгэл Газрын тухай хуулийн 16-1-15 дугаар заалтын дагуу 2022 оны 01-р сарын 01-нээс албан ёсоор улсын бүртгэлд орно.

ДЭЛ УУЛЫН ХАДНЫ ЗУРГААС СЭДЭВЛЭН ХИЙСЭН УРЛАГИЙН БҮТЭЭЛҮҮД

Хадны зургийг зөвхөн түүхийн олдвор гэдэг байсан цаг ард үлдэж эдүгээ хадны зургийг урлаг талаас нь сонирхох, мөн урлагийн бүтээл болгох талаар ч олон уран бүтээлчид ажиллаж байна. Зөвхөн уран зургийн бүтээлд оруулж байсан бол сүүлийн үед уран баримал, монументаль чимэглэл, контенпорари урлагийн эх үүсвэр төдийгүй бүжгийн урлагт хүч түрэн орж ирж байна. Тухайлбал доктор С.Дулам, УГЗ Д.Баярбаатар, Д.Энхгэрэл нарын уран бүтээлчид хамтран Дэл уулын 32 хүнт хэмээх дөрвөлжин булшний зураг, нөхөн үржихүйн холбогдолтой зураг, тамга тэмдэг, ахуйн холбогдолтой зургуудаас сэдэвлэн "Хөмөргөн гурвалжин", "Босоо цагаан гурвалжин" зэрэг бүрэн хэмжээний хоёр бүжгэн жүжиг тавьсан.

Эдгээрийн нэг нь Парис хотод ЮНЕСКО-гийн төв байрны тайзан дээр тоглогдсон нь гадаадын үзэгчдийн сонирхлыг ихээхэн татаад байгаа.



Дэл уулын олон хадны зургийг Төрийн шагналт зураач Цэрэннадмидын Цэгмэд П.Байгаль, Ц.Солонго нарын олон уран зураачид дүрслэх урлагийн бүтээл болгож байгаа. Хадны зургаас сэдэвлэн урлагийн төрөл бүрийн бүтээл туурьвах явдал уран бүтээлчдийн дунд ялангуяа залуу зураачдын дунд нилээд дэлгэрэх шинжтэй байгаа. СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн дээд сургуулийн багш оюутнууд сүүлийн жилүүдэд Дэл уулын хадны зургаар үйлдвэрлэлийн дадлага хийж олон уран бүтээл хийсэн.



Дэл уулын хадны зураг нь бусад газрын зургаас уран сайхан, зураглал, ур хийцийн хувьд илүү өвөрмөц болохыг мэргэжлийн урлаг судлаачид дүгнэдэг.

Хадан дээрх ихэнх зураг нь эртний хүмүүсийн өвөрмөц сэтэхүй, эдүгээ бидний үеэс тэс өөр хэв загвар зонхилж байдаг тул шинэ цагийн шинийг эрэлхийлэгч уран бүтээлчид тэдгээрээс илүү нарийн юм олж харах гэж санаа авах гэж очдог болсон.

Дэл уулын хадны зурган дотор хүний санаанд оромгүй сонирхолтой шийдлээр зурсан зургууд элбэг байна гэж хадны зургийн чиглэлээр олон газар явж судалгаа хийсэн СГЗ зураач П.Цэгмид, Төрийн шагналт Ц.Цэгмэд, До.Болд, кино найруулагч Б.Баяр нарын олон уран бүтээлчид дүгнэдэг.

Хадны зургийн ил үзвэрийн газар байгуулан хадан дээрх зурагтай холбоотой зохиомжит тоглолт хийх зэргээр аялал жуулчлалд ашиглаж эхэлсэн нь зохих үр дүнд хүрч байгаа тул цаашид улам өргөжүүлэх шаардлагатай байгаа юм.

ДЭЛ, ХӨНЖИЛ НУТГИЙН СОЁЛЫН БИЕТ БА БИЕТ БУС ӨВ

Монголын өмнөд говийн ард түмний төлөөлөл болох Дундговь аймгийн Дэл, Хөнжил нутгийнхан нь өвөрмөц зан заншил, өв соёл, түүх намтартай ард түмэн.

Судлаачдын үзэж байгаагаар Дэл, Хөнжил, Буурал угалз орчмын хүн ард нь бусад газрынхаас илүү ухаалаг, оюунлаг алдартнууд, урлагийн авьяастан, хутагт хувилгаад, шашны зүтгэлтнүүд, урлаг, соёлын авьяастнууд, хөдөлмөрийн сайчууд олноор төрж гарсан байдаг. Зөвхөн сүүлийн 100 жилд Дэл уулын хүн ардын дундаас МУ-ын баатар, Төрийн шагналтан, Ардын болон гавьяат цолтнууд 20 гаруй, МУ-ын Ерөнхий сайд зэрэг төр нийгмийн зүтгэлтнүүд, түүх, эдийн засаг, боловсрол, анагаах ухаан, хууль зүйн шинжлэх ухааны эрдмийн зэрэгтэй олон эрдэмтэд төрөн гарсан байдаг юм. Түүх соёлын дурсгал элбэгтэй энэ нутгийн хүн ард нь аль ч үедээ ухаалаг, оюунлаг, ажилсаг, онцгой авьяас чадвартан элбэг байсан тухай ард олны дунд үе дамжин яригдаж ирсэн домог, хууч яриа элбэг байдаг.

Дэл уулын хүн ардын ардын өвөрмөц өв соёлыг соёлын аялал жуулчлалд өргөнөөр ашиглах боломж байгаа юм. Дэл уулын хамгийн сайхан орчинд байгуулагдсан Булаг билүүний хийдэд тухайн үедээ 100 гаруй ламтай шашны төв байсан юм билээ. Энэ хийдийн туурин дээр одоо сүсэгтнүүд очиж бясалгал хийдэг, адис авдаг, ном хурдаг тухай нутгийнхан ярьдаг.

Дэл ууланд шагайн тойром хэмээх ардын уламжлалт шагай харвааны соёлын арга хэмжээ эртнээс явж ирсэн түүхтэй. Дэл уулын хад нь хадны зургийн өлгий төдийгүй янгир ямааны, аргаль хонины өлгий нутаг. Хэдэн мянган жилийн өмнө хадан дээр нь зурагдсан эдгээр ан амьтантай холбоотой домог, түүх олон байдаг.

Дундговь аймгийн Өлзийт сумын аялал жуулчлалын тогтмол хийдэг эвентийг Дэл уулын соёлын өв, Дэл Хөнжил нутгийн соёл, мөн энэ нутгийн хүн ардын өвөрмөц зан заншил, биет ба биет бус өвийг сурталчлах, өвлүүлэн уламжлуулах, хамгаалах чиглэлээр хийдэг болгох хэрэгтэй.

ДЭЛ УУЛЫН ХАДНЫ ЗУРГИЙН ТАЛААР СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД ХИЙГДСЭН АЖЛУУД

Сүүлийн таван жилд Дэл уулын түүх, соёлын дурсгалт газрын хадны зургийг хамгаалах, сурталчлах талаар дараах ажлуудыг хийсэн. Үүнд:



“ДЭЛ УУЛЫН ХАДНЫ ЗУРАГ” ҮЗЭСГЭЛЭН





1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хэмжээнд сурталчилж байгаа,
2. Дэл уулыг улсын тусгай хамгаалалтад авахуулах ажил хийгдэж байгаа.
3. Дэл уулын хадны зурагтай нутгийн бүсийн тогтоож кадастрын улсын бүртгэлд бүртгүүлсэн.
4. Дэл уулын хадны зургаар 4 удаа томоохон үзэсгэлэн гаргасан.
5. Дэл ууланд байсан хас тэмдэг сийлсэн том хэмжээний чулууг Дундговь аймгийн музейд татаж авсан.
6. Дундговь аймгийн музейд Дэл уулын хадны зургийн төрөлжсөн танхим байгуулсан,
7. Дэл уулын хадны зургаар баримтат кино, ном, фото зургийн цомог, телевизийн нэвтрүүлэг, контент хийж олны хүртээл болгосон.
8. Эрдэмтэд, судлаачид, уран бүтээлчдэд Дэл уулын хадны зургийг газар дээр нь аваачиж үзүүлэх зэрэг ажлыг хийж зохих үр дүнд хүрсэн.

БОАЖЯ, Соёлын яам, ШУА, Дундговь аймаг, Өлзийт сумын 2021-2025 оны ажлын төлөвлөгөөнүүдэд Дэл уулын түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалах, сурталчлах, тэнд аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд тусгуулан эхнээсээ хэрэгжиж эхлээд явж байна.

2021 онд “Дэл уулын гайхамшиг” ТББ-аас БОАЖЯ-нд хүсэлт тавьснаар 40 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж Дэл уулын Өлзийтийн хуудсанд жуулчдад зориулсан сүүдрэвч, машины зогсоол, мэдээллийн самбар, бие засах газар, Цагаан суварга дээр машин орохыг хязгаарлах шон, сүүдрэвч зэргийг байгуулсан.

2008 онд Дундговь аймгийн музейгээс 50 ширхэг зурган дээр төмөр пайз босгосон бол 2021 онд Өлзийт сумын Соёлын төвөөс Өлзийтийн хуудас, 32 хүнт, Баруун билүүний туурь зэрэг газарт 10 гаруй мэдээллийн жижиг самбар босгосон.

МУ-ын Засгийн газрын “Чулуун соёлын өв” хөтөлбөрт тусгагдсан хадны зургийг аялал жуулчлалын эргэлтэд оруулах, ил үзвэрийн газар байгуулах, үзэсгэлэн гаргах, ном хэвлүүлэх, баримтат кино бүтээх зэрэг ажилд Дэл уулын хадны зургийг өргөн хэмжээнд оруулахаар холбогдох газруудтай тохиролцсон байгаа.

Монголоос маш цөөн тоогоор олдоод буй олон хүн нэг дор бүжиглэж буй дүрс бүхий “32 хүнт”, Нөхөн үржихүй” зэрэг зургуудаар “Хөмөргөн гурвалжин”, “Босоо цагаан гурвалжин” бүжгэн жүжгүүд тавигдаж “Хөмөргөн гурвалжин” нь Парис дахь ЮНЕСКО-гийн төв байранд урилгаар тоглогдсон.

Бичээчийн Батмөнх
2023 он